



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үндэсний их баяр наадмын үеэр эмнэлгийн
тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг
хангаж ажиллах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ойн баярын үеэр эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг тасралтгүй ханган ажиллах, хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдал, хоол, хүнсээр дамжих хордлого, халдвар, осол гэмтэл зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт дараах АЛБАН ДААЛГАВРЫГ хүргүүлж байна:

Нэг. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг тасралтгүй хангах чиглэлээр:

1.1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам"-ыг чанд мөрдөн ажиллах;

1.2. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 102 жилийн ойн баярын үеэр байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс шаардлагатай тохиолдолд орлон ажиллах болон дуудагдан ажиллах эмч, мэргэжилтэн, ажилтны хуваарийг баталж, зохицуулалт хийх;

1.3. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, цус цусан бүтээгдэхүүн, хүчилтөрөгчийн нөөцийг бүрдүүлэн, эмнэлгийн техник, тоног төхөөрөмж болон хийн хангамжийн бэлэн байдлыг хангаж, тасалдал, хомсдол үүсгэхгүй байх;

1.4. Анхан шатны эрүүл мэндийн төв нь хяналтанд буй бага насын хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хавсарсан эмгэгтэй жирэмсэн эх, төрөх эхчүүд, хэвтрийн, хүнд өвчтөнийг баяр, наадмын амралтын өдрүүдээс өмнө заавал үзэж, зөвлөгөө өгөх, баяр наадмын өдрүүдэд дээрх иргэдтэй цахимаар болон утсаар холбогдож, биеийн байдалд тогтмол хяналт тавих;

1.5. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь шаардлагатай тохиолдолд зөвлөх эмч нараас эрүүл мэндийн байгууллагуудад цахимаар зөвлөгөө өгөх зохицуулалт хийх, эргэх холбоотой хамтран ажиллах;

1.6. Эмнэлгийн яаралтай тусламжийг ямар ч тохиолдолд харьялал харгалзахгүй, хүндэрэл, чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авах;

1.7. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажлын байраа орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчлийг гаргахгүй байх, ажлын байран дээр хариуцлагатай ажиллах;

1.8. Байгууллагууд баяр наадмын үеэр ажиллах хуваарь, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтны утасны дугаарыг баяр наадмаас өмнө олон нийтэд ил тод байршуулах;

Хоёр. Эрүүл мэндийн аюулгүй байдал, хоол, хүнсээр дамжих хордлого, халдварт, осол гэмтэл зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

2.1. Эмнэлгийн барилга байгууламж (дээврээс ус гоожих, барилгын зоорийн давхар) усанд автах, цахилгаан тасрах, эмнэлгийн тоног төхөөрөмжүүд гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх зэрэг эрсдлээс сэргийлж, ус зайлшуулах, цахилгааны нөөц эх үүсвэрийг бэлэн байлгах;

2.2. Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд “Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 2023 оны 08-00/01 дүгээр удирдамжийн дагуу бусад холбогдох хяналтын газруудтай хамтарсан хяналт шалгалтыг хийж, хоол, хүнсээр дамжих хордлого, халдварт, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;

2.3. Хоолны хордлого, осол гэмтэл, наршилт, түлэгдэлт, мөгойд хатгуулах, үер усны аюул зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бага насын хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх зэрэг мэдээлэл сурталчилгааны ажлыг баяр наадмын өмнө болон баяр наадмын үеэр аймаг, нийслэлийн онцгой комисс, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд болон өөрсдийн албан хаағчдыг эрсдэлээс сэргийлсэн сээрэмжлүүлэг, зөвлөмж хүргүүлэх;

2.4. Тарваган тахал өвчний байгалийн голомтод нутагт зорчихдоо тарвага мэрэгчтэй ойртохгүй байх, тарваганы гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн хэрэглэхгүй байх талаар сурталчлах, голомтод нутагт файз, анхааруулга байршуулах;

2.5. Хачгаар дамжих халдвартын эрсдэлээс сэргийлж, хачигт хазуулахаас сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх;

Гурав. Баяр наадмын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээллийн урсгалыг зохицуулах чиглэлээр:

3.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд нь баяр наадмын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр, хяналт тавих удирдах албан тушаалтны хуваарь, тогтмол нээлттэй байх утасны

дугаар, цахим хаягийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд 2023 оны 07 дугаар 05-ны өдрийн дотор ирүүлэх;

3.2. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн байгууллагын ажиллах нийтлэг журам”-д заасан мэдээний урсгалын дагуу мэдээ, мэдээллийг холбогдох байгууллагад тогтоосон цаг хугацаанд нь үнэн зөв ирүүлэх;

3.3. Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг олон нийтэд ил тод байршуулан, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, мэдээлэх;

3.4. Эрүүл мэндийн байгууллагууд тусlamж, үйлчилгээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээг мэдээлэх бүртгэх АМ-36”, “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33” маягтын дагуу тухай бүр бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх;

3.5. Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, тодорхой хийсэн ажлын талаарх тайланг заалт бүрээр гаргаж 07 дугаар сарын 17-ны өдрийн дотор тус яамны Эмнэлгийн тусlamжийн газарт ирүүлэх;

Дөрөв. Хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдал, хоол, хүнсээр дамжих хордлого, халдвар, осол гэмтэл, үер усны аюул зэрэг болзошгүй эрсдэлээс сэргийлсэн видео шторк, контент, мэдээлэл, зөвлөмжийг бэлтгэн баяр наадмын өмнө болон баяр наадмын өдрүүдээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр, цахим хуудсаар түгээж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан)-д даалгах;

Тав. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар (С.Сүнчин)-т хариуцуулж, биелэлтийг Эрүүл мэндийн сайдад 07 дугаар сарын 19-ний өдрийн дотор танилцуулахыг даалгаж байна.

САЙД  С.ЧИНЗОРИГ